



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 14 өдөр

Дугаар A/10

Биндэр сум

**Итгэмждэгдсэн төлөөлөгч
томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Биндэр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлийг эргэн төлүүлэх нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйч (Г.Тэмүүжин)-г итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2.Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг ханган, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож, хэргийн шийдвэрлэлтийн талаар тухай бүр танилцуулахыг (Г.Тэмүүжин)-д даалгасугай.

3.Хууль ёсны төлөөлөгч (Г.Тэмүүжин)-г хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхийг хангах, унаа шатахууны зардлыг тухай бүр олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН